



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/68

Мандалговь

Зохион байгуулалтын арга
хэмжээ авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.а, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Улсын Онцгой комиссын 2020 оны 05 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 08 дугаар хуралдааны шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Шинэ коронавирус "COVID-19"-ын халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах зорилгоор аймаг, сумаас гарах, орох зорчигч тээврийн хөдөлгөөнийг 2020 оны 3 дугаар сарын 10-ны 07.00 цагаас 03 дугаар сарын 16-ны 07.00 цаг хүртэлх хугацаанд түр зогсоосугай.

Хоёр. Архи, согтууруулах ундаа худалдан борлуулах, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хүнсний дэлгүүр, зоогийн газруудын архи, согтууруулах ундаа худалдан борлуулах, үйлчлэхийг 2020 оны 3 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл хугацаанд хориглосугай.

Гурав. Зорчигч тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хязгаарлалт, архи, согтууруулах ундаа худалдан борлуулах, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хүнсний дэлгүүр, зоогийн газруудын архи, согтууруулах ундаа худалдан борлуулах, үйлчилгээг хаасантай холбогдуулан тухайн цэгүүдэд хяналт тавьж, хяналтын постод ажиллаж байгаа алба хаагчдад хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн зааварчилгаа өгч баталгаажуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллахыг Онцгой байдлын газрын дарга, (хурандаа М.Адъяабаатар), Цагдаагийн газрын дарга, (цагдаагийн хурандаа О.Амарсанаа), Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат), Авто тээврийн төвийн дарга (Ц.Бямбацогт) нарт тус тус үүрэг болгосугай.

Дөрөв. Дээрх үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн зардлыг хавсралтаар баталсугай.

Тав. Шаардагдах 8,164,770 (найман сая нэг зуун жаран дөрвөн мянга долоон зуун дал) төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

482010225

Аймгийн Засаг даргын 2020
 03 дугаар сарын 10-ны өдрийн 768 дугаар
 захирамжийн хавсралт

**ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН ХӨДӨЛГӨӨНИЙГ ХЯЗГААРЛАСАНТАЙ
 ХОЛБОГДОЛТОЙ ЗАРДЛЫН ТООЦОО**

№	Материалын нэрс	Хэмжих нэгж	Норм	Хүний тоо	Өдөрт	6 хоногт зарцуулах	Үнэ	
							Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1. Хоол хүнс /постонд ажиллах алба хаагчидад/								
1	Гоймон	Кг	0.04	36	1.44	9	2,500	22,500
2	Будаа	Кг	0.06	36	2.16	13	3,300	42,900
3	Давс	ш	0.025	36	0.9	5	1,200	6,000
4	Цай	ш	0.004	36	0.144	0.864	2,500	2,500
5	Төмс	Кг	0.5	36	18	108	1,500	162,000
6	Байцай	Кг	0.1	36	3.6	21.6	1,650	35,640
7	Сонгино	Кг	0.04	36	1.44	8.64	2,000	17,280
8	Лууван	Кг	0.04	36	1.44	9	1,700	15,300
9	Манжин	Кг	0.02	36	0.72	4	1,600	6,400
10	Ургамлын тос	ш	0.025	36	0.9	5	4,200	21,000
11	Мах	кг	0.5	36	18	108	8,500	918,000
12	Элсэн чихэр	кг	0.07	36	2.52	15	2,800	42,000
13	Сүү	л	0.2	36	7.2	43	3,000	129,000
14	Талх	гр	0.3	36	10.8	65	1,500	97,500
15	Хиам	кг	0.2	36	7.2	43	10,500	451,500
16	Өндөг	ш	1	36	36	216	450	97,200
Нийт дүн								2,066,720
2. Хоол хүнс /шуурхай штаб/								
1	Гоймон	Кг	0.04	3	0.12	2	2,500	5,000
2	Будаа	Кг	0.06	3	0.18	4	3,300	13,200
3	Давс	ш	0.025	3	0.075	1	1,200	1,200
4	Цай	ш	0.004	3	0.012	0.228	2,500	2,500
5	Төмс	Кг	0.5	3	1.5	29	1,500	43,500
6	Байцай	Кг	0.1	3	0.3	6	1,650	9,900
7	Сонгино	Кг	0.04	3	0.12	2	2,000	4,000
8	Лууван	Кг	0.04	3	0.12	2	1,700	3,400
9	Манжин	Кг	0.02	3	0.06	1	1,600	1,600
10	Ургамлын тос	ш	0.025	3	0.075	1	4,200	4,200
11	Мах	кг	0.5	3	1.5	29	8,500	246,500
12	Элсэн чихэр	кг	0.07	3	0.21	4	2,800	11,200
13	Сүү	л	0.2	3	0.6	11	3,000	33,000
14	Талх	гр	0.3	3	0.9	17	1,500	25,500
15	Хиам	кг	0.2	3	0.6	11	10,500	115,500
16	Өндөг	ш	1	3	3	57	450	25,650
Нийт дүн								545,850
3. Шатахуун								
1	А-92	л	20		160	1120	1,920	2,150,400
2	Дизель түлш	л	20		160	1120	2,490	2,788,800
Нийт дүн								4,939,200
4. Бичиг хэрэг /Мэргэжлийн хяналтын газар/								
1	Бичгийн цаас	ш				16	11,000	176,000
2	Принтерийн хор	ш				9	43,000	387,000
3	Каноны хор	ш				1	50,000	50,000
Нийт дүн								613,000
Бүгд дүн								8,164,770